

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
2 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Газрын удирдлагын хэлтэс:

- ГЗБГЗЗГ, ОБЕГ, ХХААХҮЯ-ны хамтарсан "Онцгой байдлын үед орон зайн суурь мэдээллэлийг санг ашиглах нь" сэдвээр 2017 оны 01 дүгээр сарын 23-27-ны өдрүүдэд сургалтанд аймгийн ХХААГ, ОБГ-ын мэргэжилтэн нарын хамт хамрагдав.
- Аймгийн Татварын хэлтэст аймгийн нийт газрын албан татвар болон газрын төлбөр төлөгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг гаргаж 2017 оны 02 дугаар сарын 10-нд хүргүүлэв.
- 2016 оны Газрын нэгдмэл сангийн тоон болоон цахим бүртгэлийг Arc GIS программ дээр өөрчлөлтийг хийн ГЗБГЗЗГ-т хүргүүлэв.
- Газар өмчилж аваагүй тодорхойлолтыг 33 /өссөн дүнгээр/ иргэнд гаргаж өгч үйлчилсэн.

Газрын төлбөр, татварын талаар:

- 2017 оны 2 сарын 20-ны өдрийн байдлаар газрын төлбөрийн орлого 20,7 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөө 23 хувьтай байна.

Геодези, кадастрын чиглэлээр:

- Сүмбэр, Баянтал, Шивээговь сумдын хаягжилт, нэрийн зургийг албан хэрэгцээнд зориулан сум тус бүрт,
- Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын кадастрын зургийг 4 иргэнд кадастрын зургийг тус тус гаргаж өгөв.

Барилга, хот байгуулалтын чиглэлээр:

Аймгийн хэмжээнд ашиглагдаж буй барилга байгууламжийн нэгдсэн судалгаа болон ажлын зураггүй ашиглагдаж буй нийтийн эзэмшлийн орон сууцны барилгуудын дотор байгуулалтын /план/ зургийг гаргах ажлуудыг байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу хийж гүйцэтгэн ажиллаж байна.

Мэдээ, тайлан, судалгаа:

- Газар хөдлөлт гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулахын ажлын хүрээнд орон нутагт ашиглагдаж байгаа сургууль, цэцэрлэг, эмнэлэг, орон сууц чиглэлээр барилгын бүтээц хийцийн талаарх нарийвчилсан судалгааг гаргасан.

Зураг төслийн чиглэлээр:

- Сүмбэр сумын 2, 3 дугаар багийн гэр хорооллын айл өрхийг цэвэр усны шугамд холбох ажлын зургийн даалгаврыг боловсруулсан.
- Сүмбэр сумын 4 дүгээр багт шинээр олгогдсон өмчлөлийн газарт дэд бүтцийн төлөвлөлтийн ажил хийж байна.

Захиалагчийн хяналт:

- Баянтал сумын ЗДТГазртай 2017 оны хөрөнгө оруулалтын ажилд захиалагчийн хяналтын гэрээг байгуулсан гэрээний дагуу Баянтал сумын 4 дүгээр сургуулийн дотуур байрны барилгын доторх засварын ажил захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байна. Ажлын гүйцэтгэгчээр "Харвайн толгой" ХХК ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 35% Барилга байгууламжид ажил эхлүүлэх зөвшөөрөл олгох:
- Баянтал сумын 4 дүгээр сургуулийн дотуур байрны барилгын дотор засвар ажилд 2017.02.16 өдрийн №01 дугаар зөвшөөрөл олгосон.